



МОНГОЛ УЛСЫН
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
УЛСЫН КОМИССЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Ажил эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрмийн 2 дугаар зүйлийн 10а, 4 дүгээр зүйлийн 4.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд заасан хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг соён гэгээрүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр БНСУ-ын Гванжу хотод байрлалтай тус улсын Соёл, Спорт, Аялал Жуулчлалын яамны харьяа Азийн соёлын төвтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, улмаар тус төвд Говийн ноён хутагтын музейн үзмэрээр баяжуулсан “Монголын их хэлмэгдүүлэлтийн түүх” тусгай үзэсгэлэн гаргах, Данзанравжаа ноён хутагтын Соёлын хэлмэгдүүлэлтийн он жилүүдэд устгагдаж үгүй болсон соёлын үнэт өвийг тодорхойлох, түүхийн баримт материал болгон бүртгэлжүүлж, НҮБ-ын Юнеско байгууллагын “Дэлхийн баримтат өвийн жагсаалтад бүртгүүлэх төсөл”-ийн бэлтгэл ажлыг эрчимжүүлсүгэй.

2. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх төслийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор БНСУ-д ажиллах томилолтын бүрэлдэхүүнд шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг Нарийн бичгийн дарга, төсвийн шууд захирагч Г.Төгөлдөрт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Нарийн бичгийн дарга Г.Төгөлдөрт даалгасугай.

ДАРГА



С ОДОНТУЯА